



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ СОЛОНГОСЫН ПОЛИТЕХНИКИЙНИЙН КОЛЛЕЖИЙН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Нарангэрэл  
Утас: 261628 Цахим хаяг: [narangerelba@audit.gov.mn](mailto:narangerelba@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Амгалан Ахуй Аудит ХХК  
Захирал: Д.Амгалан  
Цахим хаяг: [amgalanahui.audit@gmail.com](mailto:amgalanahui.audit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

1.Аудитын гэрчилгээ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	15
3. Аудитын тайлан.....	16
3.1 Ерөнхий зүйл.....	16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	17
3.4 Материаллаг байдал .....	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал .....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
4. Аудитын илрүүлэлт .....	22
4.1 Залруулсан алдаа .....	22
4.2 Албан шаардлага .....	22
4.3 Зөвлөмж.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	24

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ СОЛОНГОСЫН  
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ГАНЧИМЭГ ТАНАА

2022.02.24 № 07/340  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 416,631.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн баталж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>585,058,654.76</b>	<b>800,873,998.28</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>235,670,806.00</b>	<b>283,180,706.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>235,670,806.00</b>	<b>283,180,706.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	25,397,920.00	15,397,920.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	210,272,886.00	267,782,786.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>349,387,848.76</b>	<b>517,693,292.28</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>226,417,779.00</b>	<b>167,578,430.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	226,314,229.00	167,467,680.00
35130	Эм боох материал	103,550.00	110,750.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>122,970,069.76</b>	<b>350,114,862.28</b>
35410	Бичиг хэргийн материал	2,099,035.00	1,627,285.00
35420	Аж ахуйн материал	115,969,580.26	115,969,580.26
35450	Барилгын засварын материал	740,000.00	740,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,161,454.50	231,777,997.02
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,157,458,700.66</b>	<b>11,877,948,973.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12,157,458,700.66</b>	<b>11,877,948,973.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>11,561,703,333.73</b>	<b>11,285,643,606.70</b>
39201	Барилга, байгууламж	10,899,448,987.00	10,899,448,987.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(730,849,843.69)	(1,011,514,325.05)
39203	Авто тээврийн хэрэгсэл	210,112,411.70	210,112,411.70
39204	Хуримтлагдсан элэгдэл	(145,173,585.80)	(173,477,882.24)
39205	Машин, тоног төхөөрөмж	3,887,003,407.15	4,750,512,098.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,153,449,999.64)	(3,879,134,628.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	797,754,125.62	819,250,097.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(503,333,046.95)	(602,413,953.33)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	304,667,000.86	304,667,000.86
39210	Хуримтлагдсан элэгдэл	(56,775,955.52)	(84,106,033.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,590,668.28	1,590,668.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,590,668.28)	(1,590,668.28)
39217	Номын фонд	52,299,833.00	52,299,833.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>595,755,366.93</b>	<b>592,305,366.93</b>
39301	Програм хангамж	25,650,000.00	25,650,000.00
39302	Хасагдуулга	(16,458,333.07)	(19,908,333.07)
39303	Бусад биет бус хөрөнгө	586,563,700.00	586,563,700.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,742,517,355.42</b>	<b>12,678,822,971.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>4,590,500.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,590,500.00</b>	<b>0.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>4,590,500.00</b>	<b>0.00</b>
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	4,590,500.00	0.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,737,926,855.42</b>	<b>12,678,822,971.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,737,926,855.42</b>	<b>12,678,822,971.91</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>1,790,616,010.16</b>
51101	Өмч: -Төрийн өмч	1,790,616,010.16	1,790,616,010.16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,025,449,845.78</b>	<b>5,966,345,962.27</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,025,449,845.78	6,025,449,845.78
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(59,103,883.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,921,860,999.48	4,921,860,999.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,742,517,355.42</b>	<b>12,678,822,971.91</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,422,691,872.50</b>	<b>4,861,307,205.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>291,581,772.50</b>	<b>1,352,773,934.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>291,581,772.50</b>	<b>1,352,773,934.31</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>261,375,772.50</b>	<b>168,972,529.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,137,000.00	164,722,529.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,470,000.00	4,250,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	58,768,772.50	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,206,000.00	1,183,801,405.31
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,131,110,100.00</b>	<b>3,508,533,271.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,078,841,100.00</b>	<b>3,335,704,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,078,841,100.00	3,335,704,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,269,000.00</b>	<b>172,828,371.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	52,269,000.00	139,950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	0.00	32,878,371.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>4,419,156,660.53</b>	<b>4,920,411,088.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,419,156,660.53</b>	<b>4,920,411,088.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,150,928,123.20</b>	<b>4,511,631,165.32</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,167,161,428.11</b>	<b>2,321,229,077.69</b>
210101	Цалин	1,830,433,923.04	1,509,730,910.05
210102	Нэмэгдэл цалин	220,383,995.07	639,640,024.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,162,000.00	171,090,000.00
210104	Урамшуулал	47,181,510.00	768,142.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>276,678,075.04</b>	<b>306,214,867.81</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	231,092,502.68	204,881,511.65
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	14,588,309.43	42,637,899.02
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,345,107.77	15,805,502.34
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,650,196.29	3,830,299.72
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	19,001,958.87	39,059,655.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>135,208,684.03</b>	<b>133,421,299.98</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	58,823,739.00	42,906,061.46
210302	Түлш, халаалтын зардал	41,486,465.32	54,518,027.96
210303	Цэвэр, бохир усны зардал	34,898,479.71	35,997,210.56
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>99,951,370.14</b>	<b>52,893,264.52</b>
210401	Бичиг хэргийн материал	3,888,540.00	5,171,290.00
210402	Тээвэр, шатахууны зардал	6,090,000.00	4,441,600.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	15,958,253.14	17,987,870.02
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	12,962,940.00	14,670,700.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	61,051,637.00	10,621,804.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>111,465,070.00</b>	<b>69,552,590.00</b>
210501	Эм	548,170.00	2,596,590.00



210502	Хоол	108,869,100.00	63,828,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,047,800.00	3,128,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>34,521,411.61</b>	<b>55,248,329.00</b>
210601	Багаж хэрэгсэл	144,100.00	650,000.00
210602	Тавилга	2,211,761.61	0.00
210604	Урсгал засвар	32,165,550.00	54,598,329.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>67,405,424.53</b>	<b>57,323,452.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,992,000.00	50,809,322.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,600,000.00	3,680,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	889,320.00	781,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,312.00	308,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	154,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,520,792.53	1,590,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,258,536,659.74</b>	<b>1,515,748,284.32</b>
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	228,077,111.03	174,287,281.43
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,030,459,548.71	1,341,461,002.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>268,228,537.33</b>	<b>408,779,923.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>196,871,912.00</b>	<b>365,875,304.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	151,576,200.00	303,468,610.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,762,300.00	60,357,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,533,412.00	2,049,394.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>71,356,625.33</b>	<b>42,904,619.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,356,625.33	42,904,619.50
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>83,048,857.9 87</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>83,048,857.87</b>	<b>0.00</b>
222001	Тоног төхөөрөмж	83,048,857.87	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)</b>	<b>(1,079,513,645.90)</b>	<b>(59,103,883.51)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>7,104,963,491.68</b>	<b>13,817,440,501.32</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>7,104,963,491.68</b>	<b>13,817,440,501.32</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,079,513,645.90)	<b>(1,079,513,645.90)</b>
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>6,025,449,845.78</b>	<b>12,737,926,855.42</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>6,025,449,845.78</b>	<b>12,737,926,855.42</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	(59,103,883.51)	<b>(59,103,883.51)</b>
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,921,860,999.48</b>	<b>5,966,345,962.27</b>	<b>12,678,822,971.91</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,279,721,600.0</b>	<b>3,615,405,400.0</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>148,611,500.0</b>	<b>106,872,129.0</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>148,611,500.0</b>	<b>106,872,129.0</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>148,611,500.0</b>	<b>106,872,129.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,141,500.0	102,622,129.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,470,000.0	4,250,000.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,131,110,100.0</b>	<b>3,508,533,271.0</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,078,841,100.0</b>	<b>3,335,704,900.0</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,078,841,100.0	3,335,704,900.0
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>52,269,000.0</b>	<b>172,828,371.0</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	52,269,000.0	139,950,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,878,371.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>3,250,846,977.2</b>	<b>3,470,975,400.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,250,846,977.2</b>	<b>3,470,975,400.0</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,982,618,439.9</b>	<b>3,062,195,476.5</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,171,625,877.2</b>	<b>2,308,114,914.9</b>
210101	Үндсэн цалин	1,624,413,322.8	1,568,818,336.4
210102	Нэмэгдэл	489,169,415.3	578,636,459.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,866,895.2	160,660,119.0
210104	Үр дүнгийн урамшуулал	34,176,243.9	-
<b>2102</b>	<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>273,068,513.0</b>	<b>319,329,030.6</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	225,189,789.7	214,724,827.1
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	47,878,723.3	29,111,909.5
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		20,856,796.5
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		14,222,698.1
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		40,412,799.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>145,208,684.0</b>	<b>123,421,300.0</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	77,834,379.3	32,906,061.5
210302	Түлш, халаалтын зардал	32,475,825.0	54,518,028.0
210303	Цэвэр, бохир усны зардал	34,898,479.7	35,997,210.6
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>78,481,978.7</b>	<b>49,573,660.0</b>
210401	Бичиг хэрэг	5,847,590.0	5,072,590.0
210402	Тээвэр, шатахуун	6,093,100.0	4,402,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,667,010.7	17,987,870.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,542,000.0	14,670,700.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,332,278.0	7,440,500.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>130,822,900.0</b>	<b>69,559,790.0</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	599,500.0	2,603,790.0
210502	Хоол, хүнс	108,869,100.0	63,828,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,354,300.0	3,128,000.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,009,150.0	<b>55,248,329.0</b>
210601	Багаж техник хэрэгсэл	5,426,100.0	650,000.0
210604	Урсгал засвар	32,583,050.0	54,598,329.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>67,696,666.9</b>	<b>57,323,452.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	59,992,000.0	50,809,322.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,600,000.0	3,680,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	889,320.0	781,930.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,312.0	308,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	154,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,812,034.9	1,590,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>77,704,670.0</b>	<b>79,625,000.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	77,704,670.0	79,625,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>268,228,537.3</b>	<b>408,779,923.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>196,871,912.0</b>	<b>365,875,304.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	151,576,200.0	303,468,610.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,762,300.0	60,357,300.0
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,533,412.0	2,049,394.0
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>71,356,625.3</b>	<b>42,904,619.5</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,356,625.3	42,904,619.5
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>28,874,622.8</b>	<b>144,430,000.0</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>28,874,622.8</b>	<b>144,430,000.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,874,622.8</b>	<b>144,430,000.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,874,622.8</b>	<b>144,430,000.0</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,874,622.8	144,430,000.0
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(28,874,622.8)</b>	<b>(144,430,000.0)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,428,704,900.0</b>	<b>3,401,973,232.5</b>	<b>26,731,667.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,428,704,900.0</b>	<b>3,401,973,232.5</b>	<b>26,731,667.5</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>3,062,574,200.0</b>	<b>3,036,097,928.5</b>	<b>26,476,271.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,277,889,700.0</b>	<b>2,282,017,366.9</b>	<b>(4,127,666.9)</b>
210101	Үндсэн цалин	1,460,296,700.0	1,542,720,788.4	(82,424,088.4)
210102	Нэмэгдэл	613,368,100.0	578,636,459.5	34,731,640.5
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	76,230,000.0	160,660,119.0	(84,430,119.0)
210104	Урамшуулал	127,994,900.0	0.0	127,994,900.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>323,456,700.0</b>	<b>319,329,030.6</b>	<b>4,127,669.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	237,391,500.0	214,724,827.1	22,666,672.9
210202	Тэтгэмжийн даатгал	21,516,300.0	29,111,909.5	(7,595,609.5)
210203	ҮОМШӨ ний даатгал	17,213,000.0	20,856,796.5	(3,643,796.5)
210204	Ажилгүйдлийн даатгал	4,303,300.0	14,222,698.1	(9,919,398.1)
210205	Эрүүл мэндийн даатгал	43,032,600.0	40,412,799.4	2,619,800.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>123,421,300.0</b>	<b>123,421,300.0</b>	<b>0.0</b>
210301	Гэрэл цахилгаан	34,762,400.0	32,906,061.5	1,856,338.5
210302	Түлш, халаалт	57,708,900.0	54,518,028.0	3,190,872.0
210303	Цэвэр, бохир ус	30,950,000.0	35,997,210.6	(5,047,210.6)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>49,659,500.0</b>	<b>49,573,660.0</b>	<b>85,840.0</b>
210401	Бичиг хэрэг	5,073,200.0	5,072,590.0	610.0
210402	Тээвэр (шатахуун)	4,402,200.0	4,402,000.0	200.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	18,032,200.0	17,987,870.0	44,330.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,670,700.0	14,670,700.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	7,481,200.0	7,440,500.0	40,700.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>94,510,600.0</b>	<b>69,559,790.0</b>	<b>24,950,810.0</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,603,800.0	2,603,790.0	10.0
210502	Хоол, хүнс	88,777,000.0	63,828,000.0	24,949,000.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,129,800.0	3,128,000.0	1,800.0
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>55,448,400.0</b>	<b>55,248,329.0</b>	<b>200,071.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	658,400.0	650,000.0	8,400.0
210604	Урсгал засвар	54,790,000.0	54,598,329.0	191,671.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>58,563,000.0</b>	<b>57,323,452.0</b>	<b>1,239,548.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,992,000.0	50,809,322.0	1,182,678.0

210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,680,000.0	3,680,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	792,000.0	781,930.0	10,070.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	308,200.0	308,200.0	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	193,600.0	154,000.0	39,600.0
210806	Мэдээллийн технологийн зардал	1,597,200.0	1,590,000.0	7,200.0
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>79,625,000.0</b>	<b>79,625,000.0</b>	<b>0.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	79,625,000.0	79,625,000.0	0.0
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>366,130,700.0</b>	<b>365,875,304.0</b>	<b>255,396.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>366,130,700.0</b>	<b>365,875,304.0</b>	<b>255,396.0</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	303,722,000.0	303,468,610.0	253,390.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,357,800.0	60,357,300.0	500.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,050,900.0	2,049,394.0	1,506.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,428,704,900.0</b>	<b>3,401,973,232.5</b>	<b>26,731,667.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,335,704,900.0</b>	<b>3,295,101,103.5</b>	<b>40,603,796.5</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,335,704,900.0	3,295,101,103.5	40,603,796.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>93,000,000.0</b>	<b>106,872,129.0</b>	<b>(13,872,129.0)</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,000,000.0	102,622,129.0	(17,622,129.0)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.0	4,250,000.0	3,750,000.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>141.0</b>	<b>141.0</b>	<b>0.0</b>
620001	Удирдах ажилтан	3.0	3.0	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	99.0	99.0	0.0
620003	Үйлчлэх ажилтан	39.0	39.0	0.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	0.0	0.0	0.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.0	0.0	0.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>172,828,371.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>172,828,371.00</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>		<b>170,527,548.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>26,097,548.00</b>
210101	Үндсэн цалин		26,097,548.00
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>		<b>144,430,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		144,430,000.00
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,300,823.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>2,300,823.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		2,300,823.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>172,828,371.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>172,828,371.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		139,950,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,878,371.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Амгалан ахуй аудит ХХК-ийн захирал Д.Амгалан, аудитор Д.Оюун нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтыг менежер Б.Даваацэрэн хэрэгжүүлсэн.

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Солонгосын политехникийн коллеж нь мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалт явуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Монгол Солонгосын политехникийн коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага, Монгол орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд өрсөлдөх, хөрвөх чадвар бүхий хүмүүнлэг ардчилсан нийгмийн харилцаанд төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэх, нийгмийн үйлчилгээний орчин бүрдүүлж иргэдэд үйлчлэхэд оршино” гэжээ.

Монгол Солонгосын политехникийн коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах,
- Захиалгат болон насанд хүрэгчдэд мэргэжил олгох төлбөртэй сургалт явуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Монгол Солонгосын политехникийн коллеж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй, Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар

баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдсөн байна.

Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын улмаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлаас 4,502,205.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 45,022.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт өмнөх оноос материаллаг зөрүүгүй байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,502,205.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 45,022.0 мянган төгрөгөөр тогтоолоо

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,694.4 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурч, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	235,670.8	283,180.7	47,509.9
Бараа материал	349,387.9	517,693.3	168,305.4
Үндсэн хөрөнгө	12,157,458.7	11,877,949.0	(279,509.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,742,517.4</b>	<b>12,678,823.0</b>	<b>(63,694.4)</b>

Богино хугацаат өр төлбөр	4,590.5	0.00	(4,590.5)
Төрийн өмч	1,790,616.0	1,790,616.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	6,025,449.9	5,966,346.0	(59,103.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,921,861.0	4,921,861.0	0.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>12,742,517.4</b>	<b>12,678,823.0</b>	<b>(63,694.4)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс сургалтын төлбөрийн авлага өссөнтэй холбоотой 47,509.9 төгрөгөөр өссөн;
- Бараа материалын данс нь КОЙКА олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 256,092.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалт 109,676.5 мянган, нийт 365,768.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 168,305.4 мянган төгрөгөөр өссөн;
- Үндсэн хөрөнгө данс КОЙКА улсын улсын байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 1,057,171.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 1,341,461.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын шийдвэрээр акталсан 176,946.6 мянган төгрөг, нийт 1,518,407.6 мянган төгрөгөөр багасаж, 279,509.7 мянган төгрөгөөр буурсан;
- Богино хугацаат өр төлбөр данс 4,590.5 мянган төгрөг тайлант хугацаанд төлөгдөж үлдэгдэлгүй болсон.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,570,624.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,570,624.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 174,407.5 мянган төгрөгөөр бууруулж 3,398,032.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 30,672.4 мянган төгрөгөөр өсгөж 3,428,704.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх болон мэргэжлийн боловсрол олгох 1 хөтөлбөр 2 арга хэмжээнд нийт 3,428,704.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,335,704.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 106,872.1 мянган төгрөг, нийт 3,442,577.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,401,973.2 мянган төгрөгийг зарцуулж үндсэн төсвөөс 40,603.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71804	Тусгай мэргэжлийн боловсрол	3,428,704.9	3,442,577.0	(13,872.1)	100.4%

1.1	80101	Үйл ажиллагааны зардал	3,062,574.2	3,036,097.9	(26,476.3)	99.1%
1.2	80802	Ажил олгогчоос олох тэтгэмж урамшуулал	366,130.7	365,875.3	(255.4)	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 32,878.4 мянга, гадаад хандив тусламжийн 139,950.0 мянга, нийт 172,828.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс үндсэн цалингийн зардалд 26,097.5 мянган, багаж техник хэрэгсэлд 144,430.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 2,300.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Солонгосын политехникийн коллежийн үйл ажиллагаа нь мэргэжлийн боловсрол олгох сургалт, техникийн боловсрол олгох сургалт гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний хэрэгжилт 96.6 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.2 хувийн биелэлттэй буюу 3,401,973.2 мянган төгрөг байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд өмнөх оноос сургалтын төлбөрийн авлага 57,509.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлогыг 85,000.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 135,500.5 мянган байна. Өмнөх 2018-2019 онуудад мөн адил гүйцэтгэлээрх орлого төсвөөс давсан байгаа нь тус байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогыг үндэслэлгүй төлөвлөж байгааг харуулж байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

- Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 148 мэдээллээс 3 мэдээлэл

хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 778,249.6 мянган төгрөгийн 63 мэдээ оруулахаас 598,922.9 мянган төгрөгийн 46 мэдээллийг оруулаагүй;

- Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 4 мэдээлэл байршуулахаас 3 мэдээлэл байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй алдаа зөрчил давтан гарсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ерөнхий нягтлан бодогчид холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын төсвийн зарцуулалтад 10-с доошгүй хувийн хэмнэлт гараагүй, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоонд нөхөн томилгоо хийсэн байна.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.2-д заасан “1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.2-д заасан “1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 516,108.1 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлснээс аудитын явцад 58,306.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжөөс шилэн дансны цахим хуудсанд 41 мэдээг хугацаа хоцроож, 15 мэдээг байршуулаагүй зөрчил, сургалтын төлбөрийн орлогод төлбөрийн цахим баримт олгоогүй, дансны авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд дахин давтагдсан байна. Төлбөрийн актын биелэлт 100 хувь, албан шаардлагын биелэлт 50 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 71 хувь, нийт 73 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	4	3,183.9	4	3,183.9	-	-	100
Албан шаардлага	4	293,332.7	2	42,987.1	2	250,345.6	50
Зөвлөмж	7	164,469.4	5	20,930.0	2	143,539.4	71
<b>Нийт дүн</b>	<b>15</b>	<b>460,986.0</b>	<b>11</b>	<b>67,101.0</b>	<b>4</b>	<b>393,885.0</b>	<b>73</b>

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын явцад хөрөнгийн түүвэр тооллогыг хийхэд тус байгууллагын санхүүгийн тайланд хөрөнгүүдийн дотоод шилжих хөдөлгөөн, өөрчлөлтийг бүртгээгүй байсан. Дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулсан эсэхийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 845,352.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 428,721.1 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 216,580.7 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 200,050.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 416,631.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь материаллаг байдлын түвшинээс 371,609.6 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдэл 344,603.1 мянган төгрөгийн тооцоогүй байна;
- 3,128.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан;
- Тайлант оны 80,990.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг дутуу тайлагнасан байна.

##### 4.2 Албан шаардлага

1. Сургалтын төлбөрийн авлага 201,182.8 мянган төгрөг, байгууллагаас авах хичээл үйлдвэрлэлийн материал худалдан авах 15,397.9 мянган төгрөг, нийт 216,580.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: ...дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн акт үйлдэн тооцоог гарахаас өмнө хянан баталгаажуулж байх албан шаардлага өгөх.

2. Сургалтын төлбөрийн орлогод төлбөрийн цахим баримт олгоогүй, дансны авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүдийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын “үнэн зөв” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын төлбөрт цахим баримт олгох, дансны авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, аудитаар илрүүлсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

3. Тус байгууллага нь хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулж баталгаажуулаагүй байна.



Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 70.1.1-д "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа"; 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг гадаад, дотоод хэрэглэгчдийг мэдээллээр хангахаар тодорхой бүртгэж, өөрчлөлт хөдөлгөөн бүрээр бүртгэл хийх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх шаардлага өгөх.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тус байгууллага нийт 200,050.9 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлого болон түрээсийн орлогод цахим төлбөрийн олгоогүй, мөн хөрөнгийн орлого, худалдан авалтын ажил гүйлгээ цахим баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй мөн санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх" ба "эрх үүрэг" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Сургалтын төлбөрийн орлогыг тухай бүрд хянан баталгаажуулж, хэрэглэгчийн цахим системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/ д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Үүнээс											
					Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцоо		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн элэгдэл 344,603.1 мянган төгрөгийн тооцоогүй байна	Элэгдэл тооцож залруулсан, цаашид алдааг давтан гаргахгүй байх	1	344,603.1	1	344,603.1								
2	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	3,128.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй, бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан	Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй ажиллах	1	3,128.0	1	3,128.0								
3	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Тайлант оны 80,990.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг дутуу тайлагнасан байна	Биет бус хөрөнгийг бүртгэж залруулсан, НББ тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	80,990.0	1	80,990.0								

4	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Сургалтын төлбөрийн авлага 201,182.8 мянган төгрөг, байгууллагаас авах хичээл үйлдвэрлэлийн материал худалдан авах 15,397.9 мянган төгрөг, нийт 216,580.7 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	Тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн акт үйлдэн тооцоог гарахаас өмнө хянан баталгаажуулж байх албан шаардлага өгөх	1	216,580.7					1	216,580.7				
5	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Сургалтын төлбөрийн орлогод төлбөрийн цахим баримт олгоогүй, дансны авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүдийг давтан гаргасан байна	Сургалтын төлбөрт цахим баримт олгох, дансны авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, аудитаар илрүүлсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах	1						1					

6	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Нийт 200,050.9 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн орлого болон түрээсийн орлогод цахим төлбөрийн олгоогүй, мөн хөрөнгийн орлого, худалдан авалтын ажил гүйлгээ цахим баримтаар баталгаажуулаагүй байна	Сургалтын төлбөрийн орлогыг тухай бүрд хянан баталгаажуулж, хэрэглэгчийн цахим системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах	1	200,050.9															1	200,050.9
Дүн					6	845,352.7	3	428,721.1	0	0	2	216,580.7	0	0	1	200,050.9						
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																						
1	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулж баталгаажуулаагүй байна	Эд хөрөнгийн тооллогыг гадаад, дотоод хэрэглэгчдийг мэдээллээр хангахаар тодорхой бүртгэж, өөрчлөлт хөдөлгөөн бүрээр бүртгэл хийх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх	1																	

2	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 148 мэдээллээс 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 778,249.6 мянган төгрөгийн 63 мэдээ оруулахаас 598,922.9 мянган төгрөгийн 46 мэдээллийг оруулаагүй; тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 4 мэдээлэл байршуулахаас 3 мэдээлэл байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй алдаа зөрчил давтан гарсан байна	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ерөнхий нягтлан бодогчид холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх	1					1		1		
---	------	-------------------------	--	---	---	--	--	--	--	---	--	---	--	--

3	МСПК	АХГ-2022/241/НА-СТА-ТШЗ	Төсвийн зарцуулалтад 10-с доошгүй хувийн хэмнэлт гараагүй, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоонд нөхөн томилгоо хийсэн байна	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх	1													1	
Дүн					3	0	0	0	0	0	2	0	1	0	1	0			
Нийт дүн					9	845,352.7	3	428,721.1	0	0	4	216,580.7	1	0	2	200,050.9			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 133/А0150058  
АХГ- 2022/241/НА-СТБ-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Сургалтын төлбөрийн орлогод төлбөрийн цахим баримт олгоогүй, дансны авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүдийг давтан гаргасан байна.


Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АМГАЛАН АХУЙ АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Д.АМГАЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264210  
9006104  
Via: /6.10.2020/ Bichig\_Kherag/Alban\_Shaardlaga/2022/0225\_Auditin\_2\_Gazar-126.Docx

CO108CC0432





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 130/А0150058  
АХГ-0022/241/НА-СТБ-ТМБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургалтын төлбөрийн авлага 201,182,786.00 төгрөг, байгууллагаас авах хичээл үйлдвэрлэлийн материал худалдан авах 15,397,920.00 төгрөг, нийт авлага 216,580,706.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: ...дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Солонгосын политехникийн коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пүрэвдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АМГАЛАН АХУЙ АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

ДАМГАЛАН



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Richig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-122.Docx

0010800410



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 128/А.0150058  
АХГ - 2022/041/НА - СТА - ТУС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана, 70.1.1 "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа"; 70.2.2 "түүхий эд, материал, түлш сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эд хөрөнгийн тооллогыг гадаад, дотоод хэрэглэгчдийг мэдээллээр хангахаар тодорхой бүртгэж, өөрчлөлт хөдөлгөөн бүрээр бүртгэл хийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол-Солонгосын политехникийн коллежийн захирал Ц.Ганчимэг, ахлах нягтлан бодогч П.Пурэвдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АМГАЛАН АХУЙ АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Д.АМГАЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Alban-Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gasar-121.Docx

0010800407



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 25 № 129/А030058  
АХГ-2020/241/НБ СТБ-ТМЗ

Улаанбаатар хот

Г Сахилгын хариуцлага ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Солонгосын политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Тайланд онд шилэн дансны цахим хуудсанд байршуулах 148 мэдээллээс 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш нийт 778,249,554.00 төгрөгийн 63 мэдээ оруулахаас 598,922,854.00 төгрөгийн 46 мэдээллийг оруулаагүй;
- Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 4 мэдээлэл байршуулахаас 3 мэдээлэл байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй алдаа зөрчил давтан гарсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ ... таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харуу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Монгол Солонгосын политехникийн коллежийн ахлах нягтлан бодогч П.Пүрэвдоржид хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол-Солонгосын политехникийн коллежийн захирал Ц.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ  
АМГАЛАН АХУЙ АУДИТ Д.АМГАЛАН  
ХХК-ИЙН АУДИТОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

№10.10.10.20/Bichig\_Kherig/Alban\_Shaardlaga/2022/0225\_Auditin\_2\_Gazar-123.Docx

0010800413

